



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 04

Номгон

Аймгийн бодлогын баримт бичигт тусгагдсан
Эрүүл мэндийн салбарын холбогдох арга
хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, иргэдийн
гомдлыг бууруулах, тусламж үйлчилгээний
үндсэн үзүүлэлтийг сайжруулах тухай

Аймгийн Эрүүл мэндийн салбар нь 2022 онд эхийн эндэгдэл гарч, нялхсын эндэгдэл 2 промилоор нэмэгдэн, перинаталь эндэгдлийн түвшин 2021 онд 6.5 байсан бол 2022 онд 7.8 болж, үндсэн үзүүлэлтүүдийн 62 хувь нь сөрөг үнэлэгдсэн.

Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд манай аймгийн Эрүүл мэндийн салбартай холбоотой 2021 онд 2, 2022 онд 33, 2023 оны эхний 5 сарын байдлаар 14 гомдол ирээд байна. Эдгээр гомдлыг нэгтгэн дүгнэж үзвэл эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, түргэн шуурхай байдал хангалтгүй гэсэн гомдол 28.5 хувь, эмч сувилагч, ажилтнуудын харилцаа хандлага муу гэж 22.4 хувь, ажлын хариуцлага хангалтгүй гэсэн асуудал 12.2 хувь, цаг захиалах, дугаар авах үйлчилгээ бэрхшээлтэй талаар 12.2, эмнэлгийн ажилтнууд тэтгэмжээ авч чадахгүй байна гэж 10.2 хувь, эм тариа тасарсан, хөнгөлөлттэй үнээр эмээ авч чадахгүй байна гэж 10.2 хувь, Нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн талаар болон бусад санал гомдол 4 хувийг эзэлж байна.

Дээрх эрүүл мэндийн салбарын анхаарал татсан үндсэн үзүүлэлтүүдийг 2023 онд сайжруулж, иргэд үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмж, аюулгүй байдал, Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой гомдол саналыг бууруулахад онцгой анхаарч, бүх шатны эмнэлгүүд ажлын уялдаа холбоогоо сайжруулан, харилцан зөвлөн туслах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаагаа сайжруулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг тогтоогоод Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.10, "Алсын хараа -2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг. Эрүүл мэндийн газрын дарга Н.Энхжаргалд

1. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 Зүрх судасны эмгэгийн тасаг зохион байгуулан, зүрхний шигдээсийн үеийн эмчилгээг хийж

0001/17

хэвшүүлэх, Уушгины дурангийн оношилгооны чиглэлээр хүний нөөцийг бэлтгэн, тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх, 2.1.2. Эрэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинетыг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх, 2.1.4. Ревматологийн эмчийг бэлтгэх, бодлогоор дэмжих, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, 2.1.5. Иргэдийн хүлээгдэл чирэгдлийг багасгаж, эрүүл мэндийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, 2.1.9. Антибиотикийг жороор олгосон байдалд хяналт үнэлгээг хийж, хариуцлагатай тогтолцоог бий болгох, Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх зэрэг заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх;

2.Эхийн эндэгдэл гарахаас урьдчилан сэргийлэх, хүүхдийн эндэгдлийг бууруулах талаар цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хяналт тавих;

3.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт, үндсэн үзүүлэлтийг сайжруулах талаар шуурхай арга хэмжээ авах, хяналт тавих;

4.Бүх шатны Эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулах, хяналт тавих;

5.Эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, ажилтнуудын сахилга хариуцлага, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх талаар зохион байгуулалттай арга хэмжээ авах;

6.Бүх нийтийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоог эрчимжүүлэх, хяналт тавих;

7.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2021 оны "Ковидын дараах иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх төлөвлөгөө батлах тухай" 6/23 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах;

8.Засгийн газрын 11-11 төвд иргэдээс ирсэн санал, гомдлыг бууруулах чиглэлээр салбарын хэмжээнд төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, хяналт тавих;

9.Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг дарга нарын 2022 оны хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хийсэн үнэлгээ, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах;

10.Эрүүл мэндийн яамнаас аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах;

Хоёр. Нэгдсэн эмнэлгийн дарга Ч.Жавзанд

1.Эхийн эндэгдэл гарахаас урьдчилан сэргийлэх, хүүхдийн эндэгдлийг бууруулах талаар цогц арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх;

2.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт, үндсэн үзүүлэлтийг сайжруулах талаар шуурхай арга хэмжээ авах;

3.Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх, чанарын алба, сувилахуйн алба, халдвар хяналтын албаны үйл ажиллагааг сайжруулах;

4.Байгууллагын эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, ажилтнуудын сахилга хариуцлага, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх талаар зохион байгуулалттай арга хэмжээ авах;

5.Эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг тогтмолжуулан, бүх нийтийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоог эрчимжүүлэх;

6.Засгийн газрын 11-11 төвд Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс ирсэн санал, гомдлыг бууруулах чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллах, урьдчилан сэргийлэх чиглэлээр эмнэлгийн ажилтнуудад заавар зөвлөгөөг тогтмол хүргэх;

Гурав. Сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт

1.Эхийн эндэгдэл, хүүхдийн эндэгдэл гарахаас урьдчилан сэргийлэх, шаардлагатай арга хэмжээг орон нутгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

2.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт, үндсэн үзүүлэлтийг сайжруулах талаар шуурхай арга хэмжээ авах;

3.Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө гарган ажиллах;

4.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн эрт илрүүлгийн үзлэгийг эрчимжүүлэх;

5.Хүүхдийн эрүүл мэндийг хяналтыг сайжруулан, "Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр"-ийн хэрэглээг нэмэгдүүлэх;

6.Эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, ажилтнуудын сахилга хариуцлага, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх;


7.Бүх нийтийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоог эрчимжүүлэхэд хамтран ажиллах;

8.Засгийн газрын 11-11 төвд сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс ирсэн санал, гомдлыг бууруулах чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллах;

Дөрөв. Албан даалгаврын явцын биелэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст 2023 оны 09 дүгээр сарын 30-ны дотор цаасаар тайлагнахыг бүх шатны Эрүүл мэндийн байгууллагын дарга удирдлагуудад даалгасугай.

Тав. Эцсийн үр дүнгийн хэрэгжилтийг 2023 оны 12 дугаар сарын 20-ны дотор Аймгийн Засаг даргын дэргэдэх Удирдлагын багт танилцуулахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т үүрэг болгосугай.

Зургаа.Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН